

# МОНГОЛ УЛСЫН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙДЫН ТУШААЛ

2010 оны 06 дугаар  
сарын 03–ний өдөр

Дугаар А/148

Улаанбаатар  
хот

Зааварт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн  
ТУШААХ НЬ:

Нэг. “Мал өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах, шалгах, дүгнэх заавар”-ыг  
хавсралтын дагуу нэмэлт, өөрчлөлт оруулсугай.

Хоёр. Мал өвөлжилт, хаваржилтын бэлтгэлээ зааврын дагуу хангаж дүн, мэдээ,  
тайлангаа жил бүрийн 10 дугаар сарын 20-ны дотор тус яамны Мал аж ахуйн бодлогын  
хэрэгжилтийг зохицуулах газарт ирүүлж байхыг аймгуудын Хүнс, хөдөө аж ахуй,  
жижиг, дунд үйлдвэрийн газрын, нийслэлийн Хөдөө аж ахуйн газрын дарга нарт тус  
тус үүрэг болгосугай.

Гурав. Мал өвөлжилт, хаваржилтын дүн, мэдээ, тайланг хүлээн авч нэгтгэн  
дүгнэж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, шийдвэрийн төсөл  
боловсруулан жил бүрийн 11 дүгээр сарын 05-ны дотор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн  
үйлдвэрийн сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж байхыг Төрийн нарийн  
бичгийн даргад даалгасугай.

Дөрөв. Энэхүү зааврыг батлагдсантай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуйн  
сайдын 2001 оны А/133 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

САЙД

Т.БАДАМЖУНАЙ

ХХААХҮ-ийн сайдын 2010 оны 6 дугаар сарын  
03-ны өдрийн А/148 дугаар тушаалаар батлав.

### **Мал өвөлжилтийн бэлтгэл хангах, шалгах, дүгнэх заавар**

#### **Нэг. Ерөнхий зүйл**

1.1 Мал сүргийн өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг жил бүр хангах, шалгаж дүгнэхэд энэхүү зааврыг мөрдөнө.

1.2 Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газраас мал сүргийн өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг сум, дүүрэг бүрээр жил бүрийн 10 дугаар сарын 20-ны дотор шалгаж дүнг 10 дугаар сарын 25-ны дотор Хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

1.3 Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь улсын хэмжээний малын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын дүнг нэгтгэн, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар асуудал боловсруулж 11 дүгээр сарын 10-ний дотор Засгийн газарт танилцуулна.

#### **Хоёр. Малын тарга хүчийг тодорхойлох**

2.1 Малыг зун, намрын улиралд бэлчээр шилэн оторлож бүх малыг дунд, дундаас дээш тарга хүч авхуулсан байна.

2.2 Малын тарга хүчийг тогтоохдоо тухайн багийн зуншлага, намаржилтын байдлыг төлөөлж чадахуйц 15-аас доошгүй өрхөд тус бүр 50 толгой бог мал, 30 толгой бод малд хяналтын жинлэлт /хэмжилт/, пүүлэлт хийж багийн нийт малын тарга хүчийг, багуудын малын төрөл тус бүрийн тарга хүчний дунджаар сумын малын тарга хүчийг тогтооно.

2.3 Нийт малд намрын тарга хүчний үзлэг шалгалт хийсний үндсэн дээр тухайн жилийн хүйтний улиралын цаг агаарын урьдчилсан төлөвт тулгуурлан хүнсэнд хэрэглэх, нядлан борлуулах малын тоог тогтоосон байна. Үүнд: дундаас доош тарга хүчтэй малыг 30-45 хоног шахан бордож зах зээлд борлуулах, өөрийн хэрэгцээнд хэрэглэхийн зэрэгцээ, оны эхний нийт малын 35-40 хувийг эдийн засгийн эргэлтэнд оруулахаар тооцно.

#### **Гурав. Хадлан, бэлчээрийн ургацыг тодорхойлох**

3.1 Бэлчээрийн ургамалжилт, ургацын байдалтай танилцсаны дараа уг бэлчээрийг төлөөлж чадахуйц 10 – 15 хэсгийг сонгон авна. Нэг ам дөрвөлжин хэмжээтэй модон эсвэл төмөр жааз бэлтгэн дээж авах талбай дээрээ байрлуулсны дараа уг хүрээн дотор байгаа бүх ургамлыг газрын хөрснөөс дээш 3 см өндөрт хайчлан дээж авч жинг гаргана. Хайчилж хадсан бүх талбайн жинг гаргана. Нийт ургацын жинг хадаж авсан талбайн тоонд харьцуулж нэг ам дөрвөлжин метр талбайн дундаж ургацыг олсны дараа 10000 – аар үржүүлж 1 га талбайн ургацыг бодож улмаар нийт бэлчээрийн талбайн хэмжээгээр үржүүлэн бүх ургацыг олно. Жишээлбэл:

<p>25 га бэлчээрийн ургац тодорхойлохын тулд 10 хэсэг газрыг сонгон авсны дараа тус бүрийн ургамлыг нэгбүрчлэн хайчлан жинг гаргасны дараа 1200 гр болжээ.</p>	<p>30 га бэлчээрийн ургац тодорхойлохын тулд 15 хэсэг газрыг сонгон авсны дараа тус бүрийн ургамлыг нэгбүрчлэн хайчлан жинг гаргасны дараа 1500 гр болжээ.</p>
<p><u>Ургацыг дараах байдлаар тооцно.</u></p> $\begin{array}{l} 10 \text{ м}^2 \text{ ----- } 1200 \text{ гр} \\ 1 \text{ м}^2 \text{ ----- } X \end{array}$ $X = \frac{1 \text{ м}^2 \times 1200 \text{ гр}}{10 \text{ м}^2} = 120 \text{ гр}$ <p><u>1 га талбайн ургац:</u></p> $\begin{array}{l} 1 \text{ м}^2 \text{ ----- } 120 \text{ гр} \\ 10000 \text{ м}^2 \text{ ----- } X \end{array}$ $X = 1200000 \text{ гр} = 1200 \text{ кг} = 12 \text{ цн}$ <p><u>Нийт 25 га талбайн ургац:</u></p> $\begin{array}{l} 1 \text{ га} \text{ ----- } 12 \text{ цн} \\ 25 \text{ га} \text{ ----- } X \end{array}$ $X = 25 \times 12 = 300 \text{ цн}$	<p><u>Ургацыг дараах байдлаар тооцно.</u></p> $\begin{array}{l} 15 \text{ м}^2 \text{ ----- } 1500 \text{ гр} \\ 1 \text{ м}^2 \text{ ----- } X \end{array}$ $X = \frac{1 \text{ м}^2 \times 1500 \text{ гр}}{15 \text{ м}^2} = 100 \text{ гр}$ <p><u>1 га талбайн ургац:</u></p> $\begin{array}{l} 1 \text{ м}^2 \text{ ----- } 100 \text{ гр} \\ 10000 \text{ м}^2 \text{ ----- } X \end{array}$ $X = 1000000 \text{ гр} = 1000 \text{ кг} = 10 \text{ цн}$ <p><u>Нийт 30 га талбайн ургац:</u></p> $\begin{array}{l} 1 \text{ га} \text{ ----- } 10 \text{ цн} \\ 30 \text{ га} \text{ ----- } X \end{array}$ $X = 30 \times 10 = 300 \text{ цн}$

3.2 Трансектийн аргаар сөөг, сөөгөн ургамал элбэгтэй газрын ургацыг тодорхойлдог. Үүнд: 50–100м урт, 1 метр өргөн /200м х 2м, 300-400м х 4м/ тэгш өнцөгт талбайг сонгон авсныг трансект гэнэ.

Гадаргуу нь жигд хэрчигдэл багатай газар жижиг /50-100метр \*1метр/ трансект, жигд бус гадаргуутай, сөөгөн ургамлын тархац, хэмжээ харилцан адилгүй байвал томоохон /200м х 2м, 300-400м х 4м/ трансектуудыг 2–4-өөр нь зэрэгцүүлэн байрлуулна.

Трансектийн аргаар ургац тодорхойлохдоо трансект доторх бүх сөөгөө тоолж том, жижиг, дунд гэх мэтээр ангилан бүлгүүдэд хуваана. Бүлэг тус бүрээс 3 –5 сөөгийг сонгон тэмдэглэж түүний малд идэгдэх ногоон навч найлзуурыг хайчлан авч тус бүрчлэн жигнэж бүлэг тус бүрийн нэг сөөгний дундаж жинг гаргана. Тухайн бүлгийн нийт сөөгний тоог нэг сөөгний дундаж жингээр үржүүлэх замаар бүлэг бүрийн сөөгөн ургамлын жинг гарган хооронд нь нэмж трансект ургацыг тогтооно.

Трансектүүдийн дундаж ургацыг цн/га-д шилжүүлэн га-гийн сөөгөн ургамлын ургацыг тооцож болно. Жишээлбэл:

100м х 1м хэмжээтэй 2 трансект авсан гэвэл:

Нэгдүгээр трансект:

Бүлгүүд	Сөөгний тоо	Сөөгний дундаж жин /гр/	Нийт сөөгний жин /гр/
Том	90	300	27000
Дунд	150	90	13500
Жижиг	300	60	18000

Трансектийн ургацыг олъё.  
27000 гр + 13500 гр + 18000 гр = 58500 гр = 58.5 кг

Хоёрдугаар трансект:

Ийм аргаар бодоход 100м x 1м хэмжээтэй хоёрдугаар трансектийн ургацыг 65.3 кг байсан гэвэл трансектийн дундаж ургац нь:

$$X = \frac{58.5 \text{ кг} + 65.3 \text{ кг}}{2} = 61.9 \text{ кг}$$

Үүнийг цн/га-гаар илэрхийлбэл:

$$\begin{array}{l} 1 \text{ м}^2 \text{ ----- } 61.9 \text{ кг} \\ 10000 \text{ м}^2 \text{ ----- } X \\ X = 619 \text{ кг буюу } 61.9 \text{ цн ургацтай байна.} \end{array}$$

### **Дөрөв. Бэлчээрийг ашиглах зохистой тоог тодорхойлох**

4.1 Бэлчээрийн нэг га талбайн даацыг дараах томъёог ашиглан тодорхойлно.

$$\text{БД} = \frac{Y}{\Theta \times X}$$

БД – бэлчээрийн даац

Y – бэлчээрийн ургац

Θ – нэг малын бэлчээрээс өдөрт идэх өвс, кг

X – нэг өрх айлын бэлчээр ашиглах хугацаа, хоногоор

Жишээлбэл: Ойт хээрийн бүслүүрийн 1 га бэлчээрийн зуны ургац 300 кг, нэг хонь өдөрт бэлчээрээс 1.9 кг өвс иднэ гэж үзээд бэлчээрээ 7 дугаар сарын 15-наас 8 дугаар сарын 15 хүртэл 30 хоног ашиглахаар тооцоог хийе.

$$\text{БД} = \frac{300 \text{ кг}}{1.9 \text{ кг} \times 30 \text{ хоног}} = 5.2 \text{ (1 га талбайд 5 хонийг 30 хоног)}$$

$$\text{Эсвэл нэг өдөр} \frac{300 \text{ кг}}{1.9 \text{ кг} \times 1 \text{ өдөр}} = 184 \text{ хонь идээшлүүлж болно.}$$

Ургамлын судалгааг үндэслэн тухайн бэлчээрийг (хаваржаа, зуслан, намаржаа, өвөлжөө, мөн отрын бэлчээр) ашиглах малын зохистой тоо толгойг тооцоолон гаргана.

Бэлчээрийн талбайг бэлчээрийн даацад үндэслэн тодорхойлохдоо:

$$\text{БТ} = \frac{\Theta \times X \times C}{Y}$$

БТ – нэг хот айл эсвэл өрхийн малд шаардагдах бэлчээрийн талбай, га

Θ – нэг малын хоногт идэх тэжээлийн норм, кг

X – мал бэлчээх хоногийн тоо

C – малын тоо

Y – 1 га талбайн бодит ургац

Жишээлбэл: 1. Ойт хээрийн бүсийн 1 га-гаас 350 кг өвсний ургац бүхий бэлчээрт 100 хонийг 90 хоног бэлчээхэд шаардагдах бэлчээрийн талбайг бодохдоо нэг хонин толгойг өдөрт бэлчээрээс 1.9 кг өвс иднэ гэж тооцвол:

$$BT = \frac{1.9 \text{ кг} \times 90 \text{ хоног} \times 100 \text{ хонь}}{350 \text{ кг/га}} = 48.9 \text{ га}$$

2. Харин өвлийн 3 сарын хугацаанд бэлчээрийн ургацыг 160 кг/га гэж үзээд хонь өдөрт 1.3 кг хагд өвс иднэ гэж тооцвол 100 хонинд:

$$BT = \frac{1.3 \text{ кг} \times 90 \text{ хоног} \times 100 \text{ хонь}}{160 \text{ кг/га}} = 73.1 \text{ га}$$

Гэвч бэлчээрийн ургац цаг агаараас ихээхэн шалтгаалах тул өвлийн бэлчээрийн хүрэлцээг одоо тооцоолсон дээрээ 30 хувийн нөөц талбай нэмж авах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл энэ жишээн дээр 21.9 га талбайг нэмж 95.0 га бэлчээр шаардлагатай гэж тооцно.

Төрөл бүрийн малын бэлчээрээс идэх өвсний хэмжээ (кг, хоног)

Төрөл	Зун	Намар	Өвөл	Хавар
Адуу	7.8	8.1	6.5	5.8
Тэмээ	14.1	13.0	8.4	9.9
Үхэр	8.7	9.7	8.4	7.4
Хонь	1.6	1.8	1.1	1.1
Ямаа	1.3	1.4	1.0	1.0

Хонин толгойд шилжүүлэх дараахь илтгэлцүүрийг бэлчээрийн даац тодорхойлох болон малд шаардагдах өвс, тэжээлийн нормыг тооцохдоо хэрэглэнэ.

№	Малын төрөл	Илтгэлцүүр
1.	Цэвэр үүлдрийн:	Үхэр
2.		Хонь
3.		Ямаа
4.	Нутгийн үүлдрийн:	Үхэр
5.		Хонь
6.		Ямаа
7.		Адуу
8.		Тэмээ
9.		Гахай
10.		Шувуу
11.	Ирэх онд гарах:	Бодын төл
12.		Богийн төл
13.		Торой
14.		Дэгдээхэй

4.2 Бэлчээрийн даац, багтаамжийг зөв тодорхойлсны үндсэн дээр өөрийн аймгийн бусад сумын нутаг, өөр аймагт болон бусад аймгаас отроор өвөлжих хаваржих өрх, малын тоо, хугацааг тогтоон тэдгээрийг зохицуулах аймаг, сумын Засаг дарга нарын хооронд гэрээ байгуулна. Гэрээнд 2 талын хариуцлагын тогтолцоог тодорхой тусгана.

Сумын Засаг дарга нар аймаг дундын тусгай хэрэгцээний отрын бэлчээрийг ашиглах талаар тус бүсийн мэргэжилтнүүдээр дамжуулан Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаатай гэрээ байгуулж хэрэгжүүлнэ.

Улсын тусгай хамгаалалттай газар, хилийн бүс, зурвас газарт мал оруулж өвөлжүүлж хаваржуулах хүсэлтээ жил бүрийн 8 дугаар сард багтаан Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

### Тав. Малын тэжээлийн хангамж

5.1 Бэлтгэсэн өвс, тэжээлийн хэмжээг пүүлж эсвэл хэмжиж гаргах бөгөөд 50-100 кг-ын даацтай жин, 20 м-ээс доошгүй урттай туузан метрийн тусламжтайгаар тодорхойлно.

Боож нуруулдсан өвсний жинг тодорхойлохдоо нуруунд орсон нийт боодлын 1 хувь буюу 100-аас доошгүй боодол өвсийг жинлэж нэг боодол өвсний дундаж жинг нуруунд байгаа нийт боодлын тоогоор үржүүлж тодорхойлно.

Нуруулдсан задгай өвсний хэмжээг гаргахад нурууны өргөн /Ө/, урт /У/, бөгрөг /Б/-ийг хэмжинэ. Өргөн, уртыг сууриас дээш 0.75-1.0 метрийн өндөрт хэмжинэ.

Нурууны эзэлхүүнийг түүний хэлбэрээс шалтгаалан дараахь томъёонуудыг ашиглан тодорхойлно. Үүнд:

- Өндөр нь өргөнөөсөө их нуруунд  $\Theta = (0.52 \times Б - 0.46 \times \Theta) \times \Theta \times У$
- Өндөр нь өргөнөөсөө бага нуруунд  $\Theta = (0.52 \times Б - 0.44 \times \Theta) \times \Theta \times У$
- Хавтгай оройтой нуруунд  $\Theta = (0.56 \times Б - 0.55 \times \Theta) \times \Theta \times У$
- Шовх оройтой нуруунд  $\Theta = Б \times \Theta \times У / 4$
- Бухал хэлбэртэй өндөр нуруу  $\Theta = (0.004 \times Б - 0.012 \times Б\gamma) \times Б\gamma^2$
- Бухал хэлбэртэй намхан нуруу  $\Theta = (Б\gamma \times Б^2) / 33$

Э-нурууны эзэлхүүн ( $м^3$ ), Б-бөгрөг (м), Ө-өргөн (м), У-урт (м), Б $\gamma$ -бүслүүр (м)  
1  $м^3$  өвсний жинг дараах хүснэгтийг ашиглан олно.

№	Өвсний төрөл	Хадгалсан хугацаа			
		3-5 хоносон	1 сар	3 сар	5 сар
1.	Нуга, ой, атаржсан газрын улалжтай	37-42	45-51	49-56	51-61
2.	Үетэн алаг өвст	40-45	19-55	53-60	58-65
3.	Хуурай хөндий, хээрийн үетэн-алаг өвст	45-50	55-61	58-65	64-70
4.	Үетэн-буурцагтанг	55-60	67-72	72-78	75-84
5.	Хялгана-ерхөг-биелэг өвс зонхилсон	60-65	73-79	78-85	84-91

Малын тэжээлийн хэмжээг пүүлэх бололцоогүй бол 1  $м^3$  тэжээлийн хэмжээг тодорхойлохдоо сүрэл 40 кг, улаан буудай 750 кг, арвай 650 кг, хошуу будаа 450 кг, хивэг 400 кг, лай ба өвсний гурил 150 кг, багсармал тэжээл 350 кг, хорголжин тэжээл 650 кг, тэжээлийн үндсэн үрт /манжин, төмс/ 650 кг, байцаа 400 кг, эрдэнэшиш ба буурцагт ургамлын дарш 650 кг, бусад ургамлын дарш 550 кг, өвсөн даршийг 450 кг-аар тооцно.

Жишээ нь: Нурууны бөгрөг /Б/ 16м, өргөн /Ө/ 4м, урт /У/ 12м, хадлан хадсанаас хойш 2 сарын дараа (1  $м^3$  өвсний хэмжээ 55 кг) хэмжиж байна гэж үзвэл:

$$(0.52 \times 16м - 0.46 \times 4м) \times 4м \times 12м = 311.04 м^3$$

$$311.04 м^3 \times 55 кг = 17107.2 кг \text{ буюу } 17.1 \text{ тн байна.}$$

5.2 Малд тарга хүчний үзлэг явуулсан материалыг үндэслэн байран болон нэмэгдэл тэжээлд орох малын тоог тогтооно.

Байран тэжээх малд дундаас доош тарга хүчтэй бүх мал, төв суурингийн ойролцоох бүсийн саалийн чиглэлийн бүх үхэр болон гахай, шувууг оруулах бөгөөд хангайн бүсэд 270 хоног, хээрийн бүсэд 240 хоног, говийн бүсэд 210 хоног тэжээхээр тооцно.

Нэмэгдэл тэжээлээр цэвэр үүлдрийн үхэр, хонь, ямаа, сайжирсан эрлийз мал болон хээлтүүлэгчийг 100 хувь, дунд ба дундаас дээш тарга хүчтэй тэмээ, адууны 5 хувь, үхэр, хонь, ямааны 50 хувь, ирэх онд гарах тугал, хурга, ишигний 30 хувийг оруулж хангайн бүсэд 120 хоног, хээрийн бүсэд 90 хоног, говийн бүсэд 60 хоног тус тус тэжээхээр тооцно.

5.3 Тэжээлийн хэрэгцээг тооцохдоо хонин толгойд шилжүүлснээр нэг хоногт байран тэжээх малд 15.0 мДж, нэмэгдэл тэжээл өгөх малд 7.5 мДж-аар бодно.

5.4 Аймаг, сумын өвс тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэхдээ хонин толгойд шилжүүлсэн нийт малыг нэг хонинд хоногт 1.0 кг өвс түүнтэй тэнцэх тэжээлээр тооцож тус бүр 3 хоног нэмэгдэл тэжээлээр тэжээх нөөц бүрдүүлсэн байхаар тооцно.

5.5 Малчид болон мал бүхий иргэд өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэхдээ хонин толгойд шилжүүлсэн нэг мал тутамд хангайн бүсэд 30 кг, тал хээрийн бүсэд 10 кг, говийн бүсэд 3 кг өвс, хадлан бэлтгэсэн байхаар тооцно.

5.6 Төллөсөн эх малын тэжээлийн хэрэгцээг тооцохдоо нэг хонин толгойд гарах төлийн хамт хоногт байран тэжээлд 15.0 мДж, нэмэгдэл тэжээлээр 7.5 мДж-аар хангайн бүсэд 120 хоног, хээрийн бүсэд 90 хоног, говийн бүсэд 60 хоног тэжээхээр бодно.

Төллөх эх малд шаардагдах тэжээлийн хангамжийг тооцохдоо төлийн бэлтгэл шалгаж дүгнэх үед байгаа бүх тэжээлийн 75 хувийг төллөх мал төлд, үлдэх 25 хувийг бусад малд хэрэглэнэ гэж тооцно.

Өвс, тэжээлийг солилцлын энергид шилжүүлэх илтгэлцүүр (мДж)

№	Тэжээлийн нэр, төрөл		СоЭ	Мөрдөгдөх стандарт	
1	Өвс	Байгалийн хадлан	I зэрэг	7.0-7.5	MNS 0592:2008
			II зэрэг	6.0-7.0	
		Таримал өвс	I зэрэг	7.5-8.2	
			II зэрэг		
2	Үр тарианы хаягдал	Үйлдвэрийн	Хивэгч	8.0-7.0	MNS 1080:2008
			Гахай, шувуу	9.0-10.0	
		Үтрэмийн	Хивэгч	6.0-7.0	
			Тахиа, гахай	8.0-9.0	
3	Хивэг	Хивэгч	I зэрэг	8.8	MNS 0961:2008
			II зэрэг	8.5	
			III зэрэг	8.0	
		Гахай, шувуу	I зэрэг	9.5	
			II зэрэг	9.2	
			III зэрэг	9.0	
4	Багсармал		7.31	MNS 1077:2008	
5	Хорголжин		7.31		
6	Төлийн тэжээл		8.46	MNS 2607:2008	

7	Өвсний гурил		I зэрэг	8.0-8.5	MNS 1629:2008
			II зэрэг	7.5-8.0	
8	Дарш	Эрдэнэшишийн	I зэрэг	3.7	MNS 3467:2008
			II зэрэг	32.-3.7	
			III зэрэг	3.1	
		Эрдэнэшиш, хошуу будаа, вандуй, арвайн холимог	I зэрэг	4.1	
			II зэрэг	3.5-4.0	
			III зэрэг	3.4	
		Хошуу будаа, вандуй, арвайн холимог	I зэрэг	3.5	
			II зэрэг	3.0-3.5	
			III зэрэг	3.0	
9	Амьтны гаралтай тэжээл	Мах-ясны гурил	Хивэгч	8.8	MNS 0547:2008
			Тахиа, гахай	12	
		Ясны гурил	Хивэгч	4.0	
			Тахиа, гахай	4.2	
		Махны гурил	Хивэгч	12.0	
			Тахиа, гахай	14.5	
		Цусны гурил	Хивэгч	12.4	
			Тахиа, гахай	14.2	

Өвс, тэжээлийн чанар, зориулалтыг тогтоохдоо Монгол улсын стандартуудыг баримтална.

5.7 Нэг хонин толгойд 2 кг-аар бодож давс, хужир зэрэг эрдэс тэжээл бэлтгэсэн байна. Эрдэс тэжээлийг тооцохдоо нэг шоо дөрвөлжин метр давсыг 1000 кг, хужрыг 800 кг гэж тооцно.

5.8 Малчин өрх бүр бэлтгэсэн өвс тэжээлээ жил бүрийн 10 дугаар сарын 1-ний дотор өвөлжөө, хаваржаандаа, аймаг, нийслэл, сум, дүүргийн аюулгүйн нөөцийг 10 дугаар сарын 15-ны дотор нөөцийн байгууламждаа бүрэн татсан байна.

Аймаг, нийслэлийн нөөцийг аймаг, нийслэлийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан байгууллага, сум, дүүргийн нөөцийг сум, дүүргийн ЗДТГ хариуцан бүрдүүлнэ.

Өвс, тэжээлийг хадгалалт, хамгаалалтын горимын дагуу хашиж хамгаалсан, галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсан байна.

5.9 Хадлан бэлтгэлийн төлөвлөгөөг заавал бүрдүүлэх бөгөөд хадлан бэлтгэх бололцоогүй аймаг, орон нутаг хадлангийн нөөцтэй аймаг, орон нутагтай гэрээ байгуулах замаар өөрсдийн хүч, нөөцөөр бэлтгэсэн бусад гар болон эрдэс тэжээл, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээр солилцох, хадлан бэлтгэлийн үеэр ажиллах хүн хүч, техник хэрэгслээр туслалцах зэрэг зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг авч ажиллана.

### Зургаа. Усан хангамж

6.1 Өвөл, хаврын улиралд малыг ундарга сайтай худаг, харз, голын усаар хангахаар тооцно. Усны хэрэгцээг тооцохдоо өвөл, хаврын улиралд нэг хоногт тэмээ 40-50 л, адуу 20-30 л, үхэр 30-40 л, хонь, ямаа 2-3 л, гахай 20-30 л, шувуу 0.5-0.8 л бодын төл 10-20 л, богийн төл 1-2 л, торой 10-15 л, дэгдээхэй 0.2-0.4 л ус хэрэглэхээр бодно. Усан сан байгуулах, зөөврийн усны хэрэгцээг тооцоход эдгээр үзүүлэлтүүдийг ашиглана.

6.2 Усны нөөц хүрэлцээгүй, малаа бэлчээрээр явуулж худаг, уст цэгээс услах боломжгүй, цасны усаар малаа ундаалдаг, мөн худаг хүртэлх зай нь бог малд 3 км, үхэрт 4 км, адуунд 10 км-ээс хол байгаа өрхийг усаар дутагдалтай өрхөд хамааруулж тооцно.

6.3 Худаг болон уст цэгийн дулаалгыг хийж, ойр байгаа айл буюу хувь хүнд эзэмшүүлж хамгаалуулна.

6.4 Шинээр гаргасан худаг, уст цэгийг тодорхойлохдоо улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын төсөл, хөтөлбөрийн санхүүжилтээр, аймаг, орон нутгийн өөрсдийн хүч хөрөнгө, малчдын санаачилгаар гаргасан худгийн тоо, хөрөнгийн хэмжээг тусгана.

### **Долоо. Малын хашаа, байрны хангамж**

7.1 Цэвэр үүлдрийн болон эрлийз мал, гахай, шувууг битүү дулаан байранд, нутгийн үүлдрийн үхэр, бог малыг дулаалгатай, саравчтай хашаанд өвөлжүүлэхээр бэлтгэнэ. Бусад нас хүйсний малыг бололцоотой хашаа байраар хангана.

7.2 Малын хашаа байрны багтаамжийг тооцохдоо нэг үхэрт 3.0, адуунд 3.0, тэмээнд 4.0, бог малд 0.8, гахайнд 2.5, шувуунд 0.2, тугал, унаганд 1.0, ботгонд 1.5, богийн төлд 0.3, торойнд 0.8, дэгдээхэйд 0.1 ам дөрвөлжин метр талбай тус тус оногдохоор бодно. Үүнд нарлах, тэжээх талбайн хэмжээ хамаарахгүй.

7.3 Хангайн бүсэд малыг 11-5 дугаар сард, говь хээрийн бүсэд 12 сараас байр, хашаанд оруулахаас гадна бод мал шуурганд уруудах замыг тосч хашаа, хорго барьсан байна.

7.4 Өвөлжөөнд байх малын дэвсгэрт зориулж хонинд шилжүүлсэн нэг толгой малд ойт хээрийн бүсэд 30 кг, хээрийн бүсэд 20 кг, говийн бүсэд 15 кг дэвсгэр бууц нөөцөлнө.

7.5 Өрх бүрт тэжээх бод малд 50 см, бог малд 25 см-ээр бодож тэжээлийн онгоц өвсний сараалж бэлтгэсэн байна.

### **Найм. Гахай, шувуу өвөлжүүлэх бэлтгэл хангах**

8.1 Бүх нас хүйсний гахай, шувууг битүү дулаан байраар хангаж, засвар дулаалга ариутгал, халдваргүйжүүлэлтийг хийсэн байх шаардлагатай.

8.2 Гахай, шувууны ус, дэвсгэр, байрны талбайн нормуудыг энэ журмын 6.1, 7.1, 7.2 дахь заалтуудын нормативыг мөрдөх ба тэжээл нь дараах нормтой байна.

№	Тэжээлийн төрөл	Тэжээлийн жорд эзлэх хувь	
		Гахай	Шувуу
1.	Хүчит тэжээл	60-70	35
2.	Амьтны гаралтай тэжээл	5-10	5
3.	Үндсэн үрт	10-15	-
4.	Дарш, багсармал тэжээл	10-15	5
5.	Ногоон тэжээл, өвсний гурил	5-10	5

## **Ес. Малчдын бэлтгэл хангах талаар**

9.1 Гэрийн дулаалга, хүрэлцэх хэмжээний хоол хүнс, дулаан хувцас, аргал түлш, уналга, хөдөлмөрийн багаж хэрэгсэлээ бэлтгэсэн байна.

9.2 Өвөлжөө, хаваржааны орчноо цэвэрлэж, мал эмнэлэгийн ариун цэврийн шаардлагыг хангасан байна.

9.3 Малдаа намрын үзлэг ангилалт, заазлалт сайн хийж мал эмнэлэгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ, угаалга тарилга, туулгалтанд бүрэн хамруулсан байна.

## **Арав. Мал сүргийн өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангасан байдлыг дүгнэх**

10.1 Мал өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг сумаас томилогдсон комисс баг, өрхөөр явж тогтоох бөгөөд аймгийн комисс нь сумуудаас ирүүлсэн тайлан, мэдээ, судалгаанд үндэслэн аймгийн дүнг гаргана. Аймгийн комисс өвөлжилтийн бэлтгэл хангалтын дүнг бүх суманд явж газар дээр нь үзэж шалгана. Мөн шаардлагатай тохиолдолд Засгийн газраас томилогдсон ажлын хэсэг өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангасан дүнг аймаг, орон нутагт газар дээр нь үзэж шалгана.

10.2 Мал өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангасан байдлыг малын тарга хүч, тэжээл, ус, хашаа, байрны хангамж, өрхийн бэлтгэл гэсэн үндсэн үзүүлэлтээр оноогоор дүгнэнэ.

10.3 Мал өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг аймаг, нийслэлд 80, суманд 85, баг, эрчимжсэн аж ахуй, фермд 90-ээс дээш оноо авсан байвал бэлтгэл хангасанд тооцно.

## **Арваннэг. Хариуцлага тооцох**

11.1 Хөдөө аж ахуйн асуудал хариуцсан Төрийн захиргааны төв байгууллагаас мал өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангаагүй, хангалтгүй биелүүлсэн холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох саналыг тухайн албан тушаалтныг томилсон эсвэл дээд шатны байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

.....оОо.....















### Бэлчээрийн нийт хүрэлцээ, хангамж

Хүснэгт-4

№	Сум, дүүргийн нэр	Ашиглагдаж байгаа нийт бэлчээр			Байгаа малын тоонд харцуулснаар шаардагдах нийт бэлчээр			Бэлчээр хангамжийн хувь
		Бэлчээрийн талбайн хэмжээ /га/	Ургац		Бэлчээрийн талбайн хэмжээ /га/	Ургац		
			Нэг га-гийн дундаж ургац, цн	Нийт ургац тн		Нэг га-гийн дундаж ургац	Нийт ургац тн	
	А	1	2	3	4	5	6	7
1								
2								
3								
4								
5								
6								
7								
8								
9								
10								
11								
12								
13								
14								
15								
16								
17								
18								
19								
20								
21								
22								
<b>ДҮН</b>								

